

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Балансын данстай холбоотой асуудал	Error! Bookmark not defined.
3.1.1	Илрүүлэлт.....	12
3.1.2	Батламж мэдэгдэл.....	12
3.1.3	Эрсдэл.....	12
3.1.4	Өгсөн зөвлөмж	12
3.1.5	Байгууллагаас өгсөн хариу	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатарт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 21-нээс 2019 оны 02 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ол дөш хайрхан аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Палеонтологи, геологийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ол дөш хайрхан аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Палеонтологи, геологийн хүрээлэн нь Монгол Улсад палеонтологи, геологийн суурь судалгааны чиглэлээр тэргүүлэн манлайлсан ШУА-ийн харьяа "Төв Азийн Геологи судлалын томоохон төв" болон "Эртний амьтан, ургамлын судалгаа (палеонтологи)-ны олон улсын хүрээлэн (төв)" байгуулж палеонтологи, геологийн чиглэлээр дэлхийд тэргүүлэх орон болно. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Хүрээлэнгийн Зорилго:

Монгол орны Палеонтологи, Геологи судлалын чиглэлээр онолын суурь судалгаа, боловсруулалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн түвшинд явуулах, нийгэмд шинэ мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэн эх орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол улсын шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн хурлаар Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэл: Хүрээлэн нь палеонтологи болон геологийн 2 салбарын хүрээнд сээр нуруутны палеонтологи, сээр нуруугүйтний палеонтологи, палеоботаникийн палеонтологи, регионал геологи, тектоник, магматизм, металлогени ба геодинамикийн гэсэн үндсэн чиглэлүүдээр судалгаа боловсруулалтын ажил (СБА)-ыг явуулж байна.

Судалгаа боловсруулалтын ажлын зорилтууд:

- Манай гаригийн амьд ертөнцийн хөгжлийн түүхийн баримт болох эртний шим судлал (палеонтологи)-ийн чулуужсан олдворыг нарийвчлан судалж, эртний сээр нуруутан

амьтдын ангилал зүй, палеобиологи, эртний орчин тэдгээрийн хувьсал хөгжлийг тодорхойлох

- Монгол орны эртний сээр нуруугүйтэн амьтны судалгааг явуулж тэдгээрийг шинэ анги, бүлэг нэгжээр өргөжүүлэх, сээр нуруугүй амьтдын чулуужсан олдворт тулгуурлан стратиграфийн ач холбогдолыг нэмэгдүүлэх,
- Монгол орны палеоботаникийн судалгаанд сүүлийн үеийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх, эртний ургамал, усан ургамал, ургамлын үр тоосонцорын судалгааны үр дүнгээр эртний орчин, эртний уур амьсгал, эртний газарзүйг тогтоох мэдээллийг цуглуулах,
- Монгол орны регионал геологи, тектоникийн судалгааг геологийн шинжлэх ухааны онол, судалгааны аргачлалуудад үндэслэн нягтлах, олон улсын түвшинд хүрэх,
- Монгол оронд өргөн тархалттай маагмын бүрдлүүдийн геологи, петрологи-геохимийн судалгааг орчин үеийн дэвшилтэт арга аргачлалд тулгуурлан явуулах, Төрөл бүрийн ашигт малтмал бүрэлдэх зүй тогтол, гарал үүслийг тогтоох судалгааг дэлхийн төвшинд хүргэх
- Палеонтологи, геологийн мэргэжлийн сургалт, хурал, семинар зохион байгуулах, шинжлэх ухааны товхимол хэвлэн гаргах, судалгааны үр дүнг олон улсын өндөр зэрэглэлийн сэтгүүлүүдэд хэвлүүлэх.
- “Монголын палеонтологи, геологийн музей”-г байгуулж эх дэлхийн чулуун болон шим мандлын түүх, тэдгээрийн улиран хувьсах хөгжлийн түүх (эволюци)-ийн судалгаагаар бий болгосон мэдлэгээр дэлхийн шинжлэх ухааны сан хөмрөгт хувь нэмрээ оруулж, Монгол орны нийгэм эдийн засгийн хөгжилд түлхэц болох

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв: өөрчлөлт ороогүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах “шаардлагагүй” гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Палеонтологи, геологийн хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Палеонтологи, геологийн хүрээлэнд дотоод хяналтын ажилтан байхгүй.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Палеонтологи, геологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвийн байгууллага төсвөөс санхүүждэг учир санхүүжилтээс хамааралтай байдагтай холбоотой юм.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны нийт орлого 13,755,584.8 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,375,558.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	10721.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	1	10721.9	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Шатахуун, гадаад томилолттой холбоотой үүссэн "Урьдчилж төлсөн зардал" дансны зарим гүйлгээг 5-6 сарын дараа хаасан байна.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эс эхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулан 2018 онд 929,356.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 928,606.3 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь 749,9 мянган төгрөгөөр буюу 0,1 хувиар хэмнэгдсэн. Энэ нь улсын төсвийн санхүүжилт 1,271.9 мянган төгрөгөөр дутуу, үндсэн үйл ажиллагааны орлого 522.0 мянган төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү орж, нийт дүнгээрээ 749.9 мянган төгрөгөөр эх үүсвэр дутуу бүрдсэнтэй холбоотой байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 522.0 мянган төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү орсон..

2.11 Шилэн дансны мэдээлэл

Палеонтологи, геологийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100,0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Палеонтологи, геологийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Шатахуун, гадаад томилолттой холбоотой үүссэн "Урьдчилж төлсөн зардал" дансны зарим гүйлгээг 5-6 сарын дараа хаасан байна.

Энэ нь "Үнэн зөв байдал" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4-т энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Зардал буруу илэрхийлэгдэх,

3.1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

3.1.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>846,139,877.01</u>	<u>784,895,344.84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	492,300.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	492,300.00
31130	Нэмэлт санхүүжилт	00.00	492,300.00
33	АВЛАГА	599,385,370.39	601,112,262.59
33300	Татаас, санхүүжилтийн авлага	599,385,370.39	598,048,870.39
335	Бусад авлага	00.00	3,063,392.20
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,063,392.20
34	УРЬДЧИЛГАА	40,232,882.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	40,232,882.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	206,521,624.62	183,290,782.25
351	Түүхий эд материал	11,347,788.18	6,942,559.70
35110	Тусгай зориулалттай материал	11,347,788.18	6,942,559.70
354	Хангамжийн материал	195,173,836.44	176,348,222.55
35410	Бичиг хэргийн материал	10,187,540.00	11,789,428.00
35420	Аж ахуйн материал	133,010,863.44	108,240,185.58
35430	Сэлбэг хэрэгсэл	1,230,000.00	2,270,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	3,402,939.00
35450	Барилгын засварын материал	2,058,500.00	10,356,697.00
35470	Бусад хангамжийн материал	48,686,933.00	40,288,972.97
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,778,029,637.20</u>	<u>3,765,119,142.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,778,029,637.20	3,765,119,142.03
392	Биет хөрөнгө	2,777,520,887.07	3,543,881,612.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,570,218.00	1,285,964,367.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	-251,678,681.47	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,351,780.00	82,721,780.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 102,245,879.48	-82,721,780.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	965,380,830.00	1,026,749,113.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-895,859,011.73	-926,891,453.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,050,092.32	125,386,914.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,324,164.21	-94,475,555.06
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,100,901,905.00	2,100,901,905.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	112,026,190.00	19,588,526.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-109,886,528.41	00.00
39217	Ном	5,234,137.05	6,657,793.05
393	Биет бус хөрөнгө	508,750.13	221,237,530.00
39301	Програм хангамж	3,595,000.00	9,448,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,086,249.87	-5,058,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	216,847,780.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,624,169,514.21</u>	<u>4,550,014,486.87</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,169,492.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,169,492.00	00.00
413	Өглөг	2,169,492.00	00.00
4136	Бусад өглөг	2,169,492.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,169,492.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,622,000,022.21	4,550,014,486.87
51	Засгийн газрын хувь оролцоо	3,622,000,022.21	4,550,014,486.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,333,002,809.00	1,549,850,589.00
51101	Өмч: - төрийн	1,333,002,809.00	1,549,850,589.00
512	Хуримтлагдсан үр дүн	649,904,592.29	618,564,136.54
51210	Өмнөх үеийн үр дүн	649,904,592.29	649,904,592.29
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-31,340,455.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,639,092,620.92	2,381,599,761.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,624,169,514.21	4,550,014,486.87

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,181,818,200.16	1,375,558,477.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,554,032.00	59,283,071.18
120	Нийтлэг татварын бус орлого	19,554,032.00	59,283,071.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,554,032.00	59,283,071.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,449,032.00	11,477,724.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,105,000.00	47,805,347.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,162,264,168.16	1,316,275,406.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	895,026,400.00	921,356,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		921,356,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	267,237,768.16	394,642,714.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,915,000.00	129,034,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	106,322,768.16	265,608,714.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	276,392.20
134001	\ Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	276,392.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,128,777,475.21	1,369,201,955.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,097,524,061.60	1,369,201,955.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,097,524,061.60	1,350,866,985.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,625,425.43	922,708,159.27
210101	Үндсэн цалин	596,911,396.43	922,708,159.27
210102	Нэмэгдэл	69,074,530.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,289,500.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,349,999.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,128,333.39	106,749,313.05
210201	Тэтгэврийн даатгал	52,290,160.89	73,525,856.62
210202	Тэтгэмжийн даатгал	5,367,634.49	9,270,385.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,709,543.13	7,379,830.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,341,908.65	1,506,658.20
210205	Эрүүл мэндийн даатгал	13,419,086.23	15,066,582.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,648,869.00	13,269,118.03
210301	Гэрэл, цахилгаан	7,956,600.60	5,543,379.00
210302	Түлш, халаалт	13,530,202.60	3,626,706.47

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	2,162,065.80	4,099,032.56
2104	Хангамж, бараа материалын зардал	5,558,575.03	24,828,777.03
210401	Бичиг хэрэг	14,290.00	10,244,729.00
210402	Тээвэр, шатахуун	20,000.00	7,744,538.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,539,485.03	1,095,698.23
210404	Ном, хэвлэл	510,800.00	656,611.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,420,000.00	1,420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,000.00	2,218,380.03
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,448,820.00
2105	Нормативт зардал	00.00	52,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	52,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	164,500.00	75,515,276.23
210604	Урсгал засвар	164,500.00	75,515,276.23
2107	Томилолт, зочны зардал	82,033,936.00	63,980,511.00
210701	Гадаад албан томилолт	4,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	78,033,936.00	63,980,511.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,082,058.54	78,241,283.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,360,560.54	76,180,953.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	301,100.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	472,410.00	226,030.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	892,988.00	658,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,282,364.21	65,522,547.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,281,680.00	3,753,824.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	4,971,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,000,684.21	56,797,623.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,253,413.61	18,334,969.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,197,953.00	14,241,170.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,985,952.00	12,770,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,212,001.00	1,471,170.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,055,460.61	4,093,799.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,055,460.61	4,093,799.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>53,040,724.95</u>	<u>6,356,522.33</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,531,142.45	37,696,978.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,531,142.45	496,664.94
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	29,226,216.64
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	7,974,096.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-12,531,142.45	-37,696,978.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>40,509,582.50</u>	<u>-31,340,455.75</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,809,522,008.55</u>	<u>1,927,634,078.39</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,665,774.00	13,586,194.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,665,774.00	13,586,194.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,665,774.00	13,586,194.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,449,032.00	12,249,694.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,216,742.00	1,336,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,776,856,234.55	1,914,047,884.39
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	895,026,400.00	921,356,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	895,026,400.00	921,356,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	871,518,738.55	992,691,584.39
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,915,000.00	129,034,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	710,603,738.55	863,657,584.39
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,311,096.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,311,096.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,804,030,008.55</u>	<u>1,911,464,156.39</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,804,030,008.55	1,911,464,156.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,173,391,224.55	1,295,080,316.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,936,521.43	901,784,338.14
210101	Үндсэн цалин	607,222,492.43	623,206,099.41
210102	Нэмэгдэл	69,074,530.00	56,815,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,289,500.00	30,998,900.00
210104	Урамшуулал	00.00	4,153,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,349,999.00	186,609,938.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,128,333.39	105,513,483.20
210201	Тэтгэврийн даатгал	54,512,597.25	77,794,183.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,923,147.22	6,929,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,153,934.04	5,543,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,230,786.83	1,385,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,307,868.05	13,859,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,440,000.00	13,269,118.03
210301	Гэрэл, цахилгаан	6,747,731.60	5,543,379.00

210302	Түлш, халаалт	13,530,202.60	3,626,706.47
210303	Цэвэр, бохир ус	2,162,065.80	4,099,032.56
2104	Хангамж, бараа материалын зардал	8,788,673.03	15,617,590.23
210401	Бичиг хэрэг	875,990.00	5,039,400.00
210402	Тээвэр, шатахуун	680,000.00	1,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,706,493.03	1,928,690.23
210404	Ном, хэвлэл	1,552,800.00	4,029,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,420,000.00	1,420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,553,390.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,859,048.16	76,749,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,520,000.00	00.00
210602	Тавилга	1,209,900.00	00.00
210604	Урсгал засвар	25,129,148.16	76,749,660.00
2107	Томилолт, зочны зардал	74,376,943.00	64,815,272.00
210701	Гадаад албан томилолт	4,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	70,376,943.00	64,815,272.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,809,373.54	104,823,060.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	159,087,875.54	102,762,730.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	301,100.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	472,410.00	226,030.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	892,988.00	658,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,252,332.00	12,507,794.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,252,332.00	7,536,694.00
210902	ичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	4,971,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	630,638,784.00	616,383,839.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,197,953.00	14,241,170.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,985,952.00	12,770,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,212,001.00	1,471,170.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	603,440,831.00	602,142,669.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	603,440,831.00	602,142,669.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,492,000.00</u>	<u>16,169,922.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,500,000.00	15,677,622.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,500,000.00	15,677,622.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,500,000.00	15,677,622.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,500,000.00	15,677,622.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,500,000.00</u>	<u>-15,677,622.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-8,000.00	492,300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	492,300.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	609,395,009.79	3,581,490,439.71
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	609,395,009.79	3,581,490,439.71
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	40,509,582.50	40,509,582.50
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	649,904,592.29	3,622,000,022.21
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	649,904,592.29	3,622,000,022.21
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	742,507,140.41	00.00	742,507,140.41
Тайлант үеийн үр дүн	216,847,780.00	00.00	-31,340,455.75	185,507,324.25
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,549,850,589.00	2,381,599,761.33	618,564,136.54	4,550,014,486.87

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	929,356,300.00	928,606,311.67	-749,988.33	99.92
УРСГАЛ ЗАРДАЛ	929,356,300.00	928,606,311.67	-749,988.33	99.92
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	916,586,300.00	915,836,311.67	-749,988.33	99.92
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	715,174,400.00	715,174,399.41	-0.59	100.00
Үндсэн цалин	623,783,800.00	623,206,099.41	-577,700.59	99.91
Нэмэгдэл	56,815,900.00	56,815,900.00	0.00	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	30,421,200.00	30,998,900.00	577,700.00	101.90
Урамшуулал	4,153,500.00	4,153,500.00	0.00	100.00
Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	0.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,809,300.00	81,809,300.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	54,090,000.00	54,090,000.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	6,929,800.00	6,929,800.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	5,543,900.00	5,543,900.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	1,385,900.00	1,385,900.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	13,859,700.00	13,859,700.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,500,000.00	13,269,118.03	-230,881.97	98.29
Гэрэл, цахилгаан	5,400,000.00	5,543,379.00	143,379.00	102.66
Түлш, халаалт	4,500,000.00	3,626,706.47	-873,293.53	80.59
Цэвэр, бохир ус	3,600,000.00	4,099,032.56	499,032.56	113.86
Хангамж, бараа материалын зардал	13,810,000.00	13,798,190.23	-11,809.77	99.91
Бичиг хэрэг	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
Тээвэр, шатахуун	1,320,000.00	1,900,000.00	580,000.00	143.94
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	1,928,690.23	-711,309.77	73.06
Ном, хэвлэл	4,250,000.00	4,249,500.00	-500.00	99.99
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	1,420,000.00	120,000.00	109.23
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	67,243,200.00	67,243,200.00	0.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	1,830,000.00	1,830,000.00	0.00	100.00
Урсгал засвар	65,413,200.00	65,413,200.00	0.00	100.00
Томиллолт, зочны зардал	17,709,000.00	17,502,274.00	-206,726.00	98.83
Дотоод албан томиллолт	17,709,000.00	17,502,274.00	-206,726.00	98.83
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,336,600.00	3,036,030.00	-300,570.00	90.99

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	975,700.00	-24,300.00	97.57
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	143,100.00	143,100.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	226,100.00	226,030.00	-70.00	99.97
Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	33,000.00	-57,000.00	36.67
Газрын төлбөр	877,400.00	658,200.00	-219,200.00	75.02
Бараа үйлчилгээний бусад зардал	4,003,800.00	4,003,800.00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,003,800.00	4,003,800.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,770,000.00	12,770,000.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	12,770,000.00	12,770,000.00	0.00	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,770,000.00	12,770,000.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	929,356,300.00	928,606,311.67	-749,988.33	99.92
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	921,356,300.00	920,084,311.67	-1,271,988.33	99.86
Улсын төсвөөс санхүүжих	921,356,300.00	920,084,311.67	-1,271,988.33	99.86
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	8,522,000.00	522,000.00	106.53
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	8,522,000.00	522,000.00	106.53

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.14	Аудитын нэр:	Палеонтологи геологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Палеонтологи геологийн хүрээлэн			Мянган төгрөгөөр	
				САГ-2019/42/СТА-ТШЗ	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахуун, гадаад томилолттой холбоотой үүссэн "Урьдчилж төлсөн зардал" дансны зарим гүйлгээг 5-6 сарын дараа хаасан байна.	10,721.9	Зөвлөмж	Нягтлан бодогч	Э. Батчимэг
	Дүн	10,721.9			

